

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар: 11

Улаанбаатар хот

Д.Дуулалыг дотоод аудиторроор
томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.6.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, 2014 оны 208 дугаар тушаалаар батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 12.3.4.1, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын журам”-ын 1.4-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн Дамдиндоржийн Дуулалыг 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дотоод аудиторын ажил, албан тушаалд томилсугай.

2. Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээнд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлөн Д.Дуулалтай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (З.Энхболд)-д, дотоод аудиторт олгох цалин, урамшууллын санал боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Цалин, урамшууллын хороо (Ц.Түмэнхишиг)-нд, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж батлуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Жавхлантад тус тус үүрэг болгосугай.

3. Д.Дуулалын цалинг хөдөлмөрийн гэрээгээр тохирсон хэмжээгээр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Ч.Соронзонболд)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолыг Д.Дуулалд танилцуулж, холбогдох хууль, журмын дагуу ажил хүлээлгэн өгөхийг Аудитын хороо (Б.Шаравсамбуу)-нд даалгасугай.

ДАРГА



З.ЭНХБОЛД